

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/02/НА-СТА-ОНА

ТӨВ ЧАНДМАНЬ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ГАЗАР
ОНӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2020 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

| | |
|---|----|
| 1.Аудитын санал дүгнэлт..... | 3 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 5 |
| 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан | 7 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 8 |
| 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл..... | 9 |
| 3. Аудитын тайлан..... | 10 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 10 |
| 3.2 Дотоод хяналт..... | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 10 |
| 3.4 Материаллаг байдал..... | 11 |
| 4. Санхүүгийн тайлангийн тодруулга | 11 |
| 4.1 Байгууллагын үйл ажиллагаа..... | 11 |
| 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин | 11 |
| 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого..... | 12 |
| 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 15 |
| 5.1 Шилэн дансны мэдээлэл | 15 |
| 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 16 |
| 8. Аудитын илрүүлэлт | 17 |
| 8.1 Залруулсан алдаа | 17 |
| 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл..... | 0 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |
| ДЭХГ | Дулааны эрчим хүчний газар |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| ББӨ | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |

1.Аудитын санал дүгнэлт



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.03.15 № 01/208.
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Төв Чандмань ДЭХГ" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Төв Чандмань ДЭХГ" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Бид санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулах үзэл баримтлалын хамрах хүрээ нь зөвхөн санхүүгийн тайлангуудыг авч үзсэн. Үүнээс болоод суурь үзэл баримтлалынх нь хамрах хүрээ илүү өргөн болсон. Энэхүү санхүүгийн тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Байгууллагын 2021 оны зорилтот түвшний батлагдсан төлөвлөгөөгөөр нийт ашиг алдагдлыг 512.1 сая төгрөгийн алдагдалтай баталж, тайлант оны гүйцэтгэлээр 137.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Энэ нь Ковид-19 цар тахал дэгдсэний улмаас тайлант онд төлөвлөгдсөн зарим ажил хийгдээгүйгээс шалтгаалсан байна

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд

19999402

D 2022/2022 он/ALBAN BICHIG

зхамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайланд онд 2021 онд 8,147.7 сая төгрөгийн орлоготой, 8,010.7 сая төгрөгийн зардалтай ажиллаж 137.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ.

Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---------------|---|--------------------------|--------------------------|
| 1.1.1 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 27,285,473.00 | 12,521,182.76 |
| 1.1.2 | Дансны авлага | 778,762,723.45 | 698,002,197.62 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 118,682,183.50 | 13,389,412.53 |
| 1.1.6 | Бараа материал | 724,983,539.36 | 407,482,579.19 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал тооцоо | 75,475,655.68 | 37,700,386.68 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 1,725,189,574.99 | 1,169,095,758.78 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 13,548,244,152.09 | 13,504,245,895.52 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 1,462,153,839.76 | 1,457,978,444.56 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | 4,930,000.00 | 4,930,000.00 |
| 1.2.9 | Дуусаагүй барилга | 1,123,846,914.00 | 1,123,846,914.00 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 16,139,174,905.85 | 16,091,001,254.08 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 17,864,364,480.84 | 17,260,097,012.86 |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 1,515,543,522.69 | 626,330,727.38 |
| 2.1.1.3 | Татварын өр | 272,491,303.95 | 290,814,668.20 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 75,659,891.16 | 116,573,342.75 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 15,020,202.54 | 11,529,987.75 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 14,027,121.20 | 25,529,555.04 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 1,892,742,041.54 | 1,070,778,281.12 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.2 | Нөөц / өр төлбөр/ | 20,919,804.50 | 20,919,804.50 |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 20,919,804.50 | 20,919,804.50 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 1,913,661,846.04 | 1,091,698,085.62 |
| 2.3.1 | Төрийн өмч | 7,016,820,599.85 | 7,016,820,599.85 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 2,684,972,734.77 | 2,684,972,734.77 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 7,072,426,488.84 | 7,153,256,491.73 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | -823,517,188.66 | -686,650,899.11 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 15,950,702,634.80 | 16,168,398,927.24 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | 17,864,364,480.84 | 17,260,097,012.86 |

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 7,474,936,135.37 | 7,916,831,009.04 |
| 2 | Борлуулалтын өртөг | -7,515,192,930.09 | -7,565,512,011.18 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | -40,256,794.72 | 351,318,997.86 |
| 5 | Хүүгийн орлого | 880,542.17 | 0.00 |
| 8 | Бусад орлого | 34,764,812.46 | 230,903,260.65 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 129,471,751.00 | 118,871,682.18 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 70,931,546.00 | 74,947,682.73 |
| 12 | Бусад зардал | 38,044,352.33 | 251,338,604.05 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | -243,059,089.42 | 137,064,289.55 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | -243,059,089.42 | 137,064,289.55 |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | -243,059,089.42 | 137,064,289.55 |
| 24 | Орлогын нийт дүн | -243,059,089.42 | 137,064,289.55 |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| | Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|----|---------------------------------------|------------------|-------------------------------------|---------------------------|--------------------|-------------------|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 7,016,820,599.85 | 2,684,972,734.77 | 3,039,852,555.84 | -580,458,099.24 | 12,161,187,791.22 |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 7,016,820,599.85 | 2,684,972,734.77 | 3,039,852,555.84 | -580,458,099.24 | 12,161,187,791.22 |
| 4 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 4,236,622,483.00 | 0.00 | 4,236,622,483.00 |
| 5 | Өмчид гаргасан өөрчлөлт | 0.00 | 0.00 | -204,048,550.00 | 0.00 | -204,048,550.00 |
| 7 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | -243,059,089.42 | -243,059,089.42 |
| 9 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 7,016,820,599.85 | 2,684,972,734.77 | 7,072,426,488.84 | -823,517,188.66 | 15,950,702,634.80 |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 7,016,820,599.85 | 2,684,972,734.77 | 7,072,426,488.84 | -823,517,188.66 | 15,950,702,634.80 |
| 12 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 240,971,587.00 | 0.00 | 240,971,587.00 |
| 13 | Өмчид гаргасан өөрчлөлт | 0.00 | 0.00 | -160,141,584.11 | -198,000.00 | -159,943,584.11 |
| 15 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 137,064,289.55 | 137,064,289.55 |
| 17 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 7,016,820,599.85 | 2,684,972,734.77 | 7,153,256,491.73 | -686,650,899.11 | 16,168,398,927.24 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 7,383,434,493.82 | 8,923,106,155.48 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 7,162,935,993.82 | 8,090,316,700.13 |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 0.00 | 8,917,294.00 |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 220,498,500.00 | 569,845,825.44 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | | 254,026,335.91 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 7,119,881,082.60 | 8,653,847,459.01 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 1,793,955,338.00 | 1,967,291,460.00 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 525,000,000.00 | 605,200,443.50 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 647,416,147.60 | 982,249,592.01 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 712,598,018.00 | 740,412,544.23 |
| 1.2.5 | Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 3,048,205,600.31 | 3,575,206,922.67 |
| 1.2.6 | Хүүний төлбөрт төлсөн | 78,167.92 | 0.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 352,657,045.00 | 531,030,019.55 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 1,050,700.00 | 1,117,873.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 38,920,065.77 | 251,338,604.05 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 263,553,411.22 | 269,258,696.47 |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 12,759,276.17 | 7,184,240.00 |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 11,878,734.00 | 7,184,240.00 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 880,542.17 | 0.00 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 282,011,603.89 | 291,207,226.71 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 273,154,749.89 | 284,147,226.71 |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 8,856,854.00 | 7,060,000.00 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -269,252,327.72 | -284,022,986.71 |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | -5,698,916.50 | -14,764,290.24 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 32,984,389.50 | 27,285,473.00 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 27,285,473.00 | 12,521,182.76 |

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 2021 оны | | | |
|----------|--------------------------------------|----------------|--------------------|--------------------|--------------------|---------------|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт | | | | | |
| | Борлуулсан дулаан | мян.төг | 5,861,860.7 | 5,768,986.8 | 92,873.9 | 98.4 |
| | Борлуулсан цэвэр ус | мян.төг | 709,003.1 | 685,124.5 | 23,878.6 | 96.6 |
| | Татан зайлуулсан бохир ус | мян.төг | 343,547.9 | 355,597.8 | (12,049.9) | 103.5 |
| | Орон сууцны засварын орлого | мян.төг | 9,294.0 | 7,895.6 | 1,398.4 | 85.0 |
| | Бохир гэсгээлтийн орлого | мян.төг | 2,225.8 | 2,594.4 | (368.6) | 116.6 |
| | Бусад борлуулалт /зөөврийн бохир/ | мян.төг | 50,070.6 | 112,386.5 | (62,315.9) | 224.5 |
| | ХО-ын өгөөжийн орлого | мян.төг | 243,523.0 | 111,761.5 | 131,761.5 | 45.9 |
| | Гэрээт ажлын орлого | мян.төг | - | 41,820.4 | (41,820.4) | |
| | Бусад орлого | мян.төг | 177,468.7 | 161,244.9 | 16,223.8 | 90.9 |
| | СӨХ-ны орлого | мян.төг | 115,436.3 | 117,434.2 | (1,997.9) | 101.7 |
| | Санхүүжилт | мян.төг | 141,901.6 | 569,845.8 | (427,944.2) | 401.6 |
| 2 | Нийт орлого | мян.төг | 7,654,331.7 | 7,934,692.4 | (280,360.7) | 103.7 |
| | Үүнээс: Цэвэр борлуулалт | мян.төг | 7,614,331.7 | 7,916,831.0 | (302,499.3) | 104.0 |
| 3 | Нийт зардал | мян.төг | 8,164,520.6 | 7,797,628.1 | 366,892.5 | 95.5 |
| | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | мян.төг | 7,909,832.0 | 7,565,512.1 | 344,319.9 | 95.6 |
| | Ерөнхий ба удирдлагын зардал | мян.төг | 216,644.2 | 193,819.4 | 22,824.8 | 89.5 |
| | Удирдлагын зардал | мян.төг | 74,085.1 | 74,947.7 | (862.6) | 101.2 |
| | Борлуулалтын зардал | мян.төг | 142,559.1 | 118,871.7 | 23,687.4 | 83.4 |
| | Бусад зардал | мян.төг | 38,044.4 | 38,296.4 | (252.0) | 100.7 |
| 4 | Цэвэр ашиг, алдагдал | мян.төг | (510,189.1) | 137,064.3 | (647,253.4) | (26.9) |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хөрөнгийн элэгдлийг ашигласан хугацааны туршид байгуулах, НББ-ийг аккурэл сууриар хөтлөх, бэлэн бүтээгдэхүүний бүртгэл, ББӨ-ийн тооцооллыг үнэн зөв гүйцэтгэх, бараа материалын орлого зарлагын хөдөлгөөнийг тухай бүртгэж, тайлагнаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор З.Мандах нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

“Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг “Дундманхайдай аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Захирлын тушаалаар томилогдсон дотоод хяналт шалгалтын баг нь 2021 онд 32 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөж, дотоод хяналт шалгалтын хэрэгжилтийг сар бүр тайлагнасан байна. Тайлант онд Төв аймаг дахь Төрийн аудитын газраас Эрсдэлийн аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан зорилтот түвшний нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны зорилтот түвшний гүйцэтгэлийн тайланг, суурь үзүүлэлтийг батлагдсан зорилтот түвшний нийт зардлын 8,164,520.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 122,467.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 91,850.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Төв чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын эрхэм зорилго нь Зуунмод сумын хүн ам, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг стандартын ундны болон ахуйн хэрэглээний цэвэр ус болон дулааны эрчим хүчээр хангаж, орон сууц, сувагжуулалтын ашиглалт, үйлчилгээг сайжруулж, инженерийн байгууламж, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, хэрэглэгчдийнхээ эрх ашгийг дээдлэн ажиллахад оршино.

“Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хотын хүн ам, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг ундны болон ахуйн хэрэглээний стандартын цэвэр усаар хангах үйлчилгээ
- Хотын орон сууц, аж ахуйн нэгж байгууллагуудын сувагжуулалтын болон орон сууцны үйлчилгээ
- Хотын орон сууц, аж ахуйн нэгж байгууллагуудыг дулааны эрчим хүчээр хангах үйлчилгээ. Дулаан үйлдвэрлэл;
- Хотын инженерийн бүх төрлийн байгууламж, шугам сүлжээ, сантехникийн ашиглалт, засвар үйлчилгээ
- Компани нь үндсэн үйлдвэрлэл, үйл ажиллагааг дэмжсэн туслах үйлдвэрлэл

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Төв аймгийн ИТХ байх бөгөөд компанийн өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгах шийдвэр гаргаж гүйцэтгэлд нь хяналт тавина.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 63 дугаар “Аж ахуйн нэгжийг өөрчлөн байгуулах тухай” тогтоолын дагуу байгуулагдаж, хавсралтаар байгууллагын дүрмийг баталсан байна.

Байгууллагын дүрмийн 4.1.1-д заасан аймгийн ИТХ-ын бүрэн эрхийг “Компанийг өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих”, 4.2.1-д “Компанийн гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх” гэж тус тус заасан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15.2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ”, Компанийн тухай хуулийн 3.1-т “Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ”, 16.2-т “Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана” гэж заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ын бүрэлдэхүүнийг Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 12 дугаар тогтоолоор шинэчлэн байгуулж, ТУЗ-ын зөвлөл нь төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч хараат 7 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтэц оновчтой, чиг үүргийн давхардал үүсээгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 207 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны 211 дугаар “Ковид-19 цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 457 дугаар “Тариф батлах тухай” тогтоол

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|------------------|----------------|-----------------|-------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Касс дах мөнгө | 16,456.7 | - | (16,456.7) |
| Банкин дах мөнгө | 10,828.8 | 12,521.2 | (1,692.4) |
| Авлага | 897,444.9 | 711,391.6 | (186,053.3) |
| Урьдчилгаа | 75,475.7 | 37,700.4 | (37,775.3) |

| | | | |
|---|---------------------|---------------------|--------------------|
| Бараа материал | 724,983.5 | 407,482.6 | (317,500.9) |
| Үндсэн хөрөнгө | 14,677,021.0 | 14,633,022.8 | (43,998.2) |
| Биет бус хөрөнгө | 1,462,153.8 | 1,457,978.4 | (4,175.4) |
| Нийт хөрөнгийн дүн | 17,864,364.4 | 17,260,097.0 | (604,267.4) |
| Өр төлбөрийн дүн | 1,913,661.8 | 1,091,698.1 | (821,963.7) |
| Богино хугацаат өглөг | 1,892,742.0 | 1,070,778.3 | (821,963.7) |
| Урт хугацаат өглөг | 20,919.8 | 20,919.8 | - |
| Эздийн өмч | 15,950,702.6 | 16,168,398.9 | 217,696.3 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 17,864,364.4 | 17,260,097.0 | (604,267.4) |

Касс дах мөнгө оны эцэст үлдэгдэлгүй болж 16,456.7 мянган төгрөгөөр, харилцах дансны үлдэгдэл нь 12,521.2 мянган төгрөг болж, 1,692.4 мянган төгрөгөөр тус тус буурсан нь өглөгийг барагдуулснаас шалтгаалсан байна. Шалгагдагч байгууллага нь Чингисхаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байршуулсан мөнгөн хөрөнгө байхгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 698,002.2 мянган төгрөг болж, 80,760.5 мянган төгрөгөөр буурсан нь Засгийн газраас хөнгөлсөн дулаан, усны үнэ, аж ахуйн нэгж байгууллага болон айл өрхөөс авах борлуулалтын авлага барагдуулснаас шалтгаалсан байна. Авлага дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 186,053.3 мянган төгрөгөөр буурч, нийт авлагын 86.1 хувь буюу 612,508.2 мянган төгрөг нь борлуулалтын авлага байна. Борлуулалтын авлагын 27.6 хувийг төсөвт байгууллагаас авах авлага, 11.7 хувийг аж ахуйн нэгж байгууллагаас авах авлага, 9.1 хувийг айл өрхөөс авах авлага тус тус эзэлж байна. Авлагын үлдэгдлээс 7,632.2 мянган төгрөгийн найдваргүй авлага хасагдуулга хийсэн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 37,700.4 мянган төгрөг болж, 37,775.3 мянган төгрөгөөр буурсан нь үүссэн урьдчилгаа тооцоог барагдуулан тайлагнасанатай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 407,482.6 мянган төгрөг болж, 317,500.9 мянган төгрөгөөр буурсан нь шатахуун, бичиг хэрэг, хөдөлмөр хамгаалал, мэргэжлийн үйлчилгээний зардал, засвар үйлчилгээний зардалд зарцуулснаас шалтгаалсан байна. Тайлант онд худалдан авалтаар 3,211,073.1 мянган төгрөгийн хангамжийн материал бэлтгэж, 3,528,574.0 мянган төгрөгийн хангамжийн материалыг зарцуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 43,998.2 мянган төгрөгөөр буурсан нь 32 нэр төрлийн хөрөнгөд дахин үнэлгээ хийж, 35,720.8 мянган төгрөгөөр хасагдсанаас шалтгаалсан байна. Тайлант онд өөрөө үйлдвэрлэсэн 158,835.3 мянган төгрөгийн, худалдаж авсан 284,147.2 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 221,310.3 мянган төгрөгийн, дахин үнэлгээний нэмэгдэл 76,816.2 мянган төгрөгийн, нийт 741,109.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Дуусаагүй барилга данс 1,123,846.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь 2001 онд Дулааны станц ашиглалтад өгөхөөр туршилт хийгдсэн боловч Улсын комисс хүлээж аваагүй тул одоог хүртэл ашиглаагүй байна. Аймгийн орон нутгийн өмчийн газраас зохих тоног төхөөрөмжүүдийг худалдах арга хэмжээг зохион байгуулж байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,070,778.3 мянган төгрөг болж, 821,963.7 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн нэгжээс бэлтгэсэн бараа материалын өглөгийг хассанаас шалтгаалжээ.

Өмнөх үеийн хуримтлагдсан алдагдал 686,650.9 мянган төгрөг болж, 136,866.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны ба үйл ажиллагааны бус зардлын хүлээн зөвшөөрөлт, үнэлгээг аккруэл сууриар тайлагнах, хэмжих боломжтой үед хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “2021 оны төсөв”-ийг батлуулсан. Үүнээс:

- Үндсэн үйл ажиллагааны орлого 7,654,331.5 мянган төгрөг
- Үйл ажиллагааны зардал 8,164,520.6 мянган төгрөг
- Алдагдал 510,189.1 мянган төгрөгөөр батлагдсан.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын өгөөж, Бүрэн сум, СӨХ, орон нутгаас санхүүжигдэх, сумд, гэрээт ажлын орлого, үндсэн үйл ажиллагааны бус орлогоос тус тус бүрдүүлдэг. Тайлант онд нийт орлого 7,934,692.4 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, төлөвлөснөөс 3.7 хувь буюу 280,360.7 мянган төгрөгөөр давж биелсэн байна. Орлогын төсвийг гүйцэтгэлтэй харьцуулахад ариутгах татуурга 102.9 хувь буюу 9,406.3 мянган төгрөгөөр, усан сан 110.6 хувь буюу 2,643.7 мянга төгрөгөөр, бохир гэсгээлтийн орлого 118.2 хувь буюу 368.7 мянган төгрөгөөр, зөөврийн бохир 2.2 дахин буюу 62,316.0 мянган төгрөгөөр, Бүрэн сум 104.3 хувь буюу 5,914.8 мянган төгрөгөөр, СӨХ 101.8 хувь буюу 1,997.9 мянган төгрөгөөр даван биелж дулаан, цэвэр ус, орон сууцны засвар, подволын орлого, ХО-ын өгөөжийн орлого, үндсэн үйл ажиллагааны бус орлогууд тус тус тасарсан үзүүлэлттэй байна.

Дулааны орлого тасарсан нь Зуунмод сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 24.9 м3 талбайг 2021 оны 9 дүгээр сарын 15-аас ашиглалтад орно гэж тооцоолсноос, УОК-ын шийдвэрээр хөл хорио тогтоосонтой холбоотойгоор аж ахуйн нэгж байгууллага, төсөвт байгууллагуудын цэвэр усны орлого буурснаас шалтгаалсан байна. Хөрөнгө оруулалтын өгөөжийн орлого буурсан нь шинэ нөөцийн санг гүйцэтгэгч байгууллага 2021 оны 3 дугаар улиралд ашиглалтад оруулах байсныг хугацаандаа хүлээлгэж өгөөгүйгээс тус тус шалтгаалсан байна.

Тайлант онд зардлын гүйцэтгэл 7,759,331.5 мянган төгрөгөөр тайлагнагдаж, төлөвлөснөөс 367,144.7 мянган төгрөгөөр дутуу буюу 95.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайлант онд хөрөнгийн эх үүсвэр нь шийдэгдэж, холбогдох тооцоо судалгаа нь боловсруулагдан батлагдсан томоохон ажлуудыг эхлүүлэхээр төлөвлөснийг орон нутагт Ковид-19 цар тахал дэгдсэнээс олон нийтийг хамарсан үйл ажиллагаануудыг зогсоосноос зардлын гүйцэтгэл дутуу байна. Тайлант оны үндсэн үйл ажиллагааны зардлын 36.1 хувийг нүүрс түүнийг бэлтгэх ажиллагааны зардал, цалин 33.0 хувийг НДШ-ийн зардал, 8.6 хувийг цахилгааны зардал, 9.9 хувийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 3.4 хувийг дотоод хэрэгцээний усны зардал, 9 хувийг бусад зардал эзэлж байна. Нийт зардлын 93.3 хувийг үндсэн үйл ажиллагааны зардал, 2.5 хувийг удирдлага, борлуулалтын зардал, 2.7 хувийг сумдад хуваарилсан зардал, 1.8 хувийг бүрэн сумын зардал, 1.4 хувийг СӨХ-ийн зардал, 0.1 хувийг

бохир зөөврийн зардал, 0.4 хувийг гэрээт ажлын зардал, 0.5 хувийг үндсэн бус үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

“Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажилласан байна. “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ нь 38 нэр төрлийн 4,949,156.5 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 3,954,510.1 мянган төгрөгийн ажил үйлчилгээ, харьцуулалтын аргаар 36,300.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ, шууд худалдан авалтаар 958,346.4 төгрөгийн ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн.

“Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ нь 2021 онд харьцуулалтын аргаар хийх 6 ажил, үйлчилгээ, нээлттэй тендер шалгаруулалтаар 5 ажил үйлчилгээ үзүүлэх худалдан авалтын тендерийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зарлаж, шууд худалдан авалтаар 958,346.4 мянган төгрөгийн ажил үйлчилгээ худалдан авахаар хийгдсэн байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 133 мэдээллийг хугацаандаа, 12 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 3,091,766.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 2,850,624.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 230,417.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгасан, 10,723.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 49,400.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 78.4 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|-----------------|---------------------|-----------------|----------|-----------------|----------|-----------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | - | - | - | - | - | - | - |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 3 | 49,400.0 | 2 | 38,700.0 | 1 | 10,700.0 | 21.6 |
| Нийт дүн | 3 | 49,400.0 | 2 | 38,700.0 | 1 | 10,700.0 | 21.6 |

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлт 78.4 хувийн хэрэгжилттэй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулахдаа ижил нэр төрлийн бараа материал, ажил үйлчилгээг нэгтгэн, худалдан авах ажиллагааны хуулийг баримтлан тендерийг зохион байгуулсан талаар нарийвчилсан горим сорилыг хэрэгжүүлэн хяналт тавих нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 62,994.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21,613.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 41,380.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 62,994.1 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 122,467.8 мянган төгрөгийн материаллаг түвшнээс 59,473.7 мянган төгрөгөөр бага байгаа тул “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхөөр шийдвэрлэв.

8.1 Залруулсан алдаа

Аудитыг гүйцэтгэх явцад санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой залруулах алдаа илрээгүй болно.

8.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчилтэй асуудалд илрээгүй болно.

8.3 Албан шаардлага

Аудитаар 21,613.9 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Байгууллагын 2021 оны зорилтот түвшний батлагдсан төлөвлөгөөг тайлант оны гүйцэтгэлтэй тулган шалгахад Үнс тээврийн зардлыг 6,280.9 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 3,422.3 мянган төгрөгөөр, шагнал урамшууллын зардлыг 1,186.7 мянган төгрөгөөр, нийт 10,889.9 мянган төгрөгийн худалдан авалтыг батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.9-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн батлагдсан зорилтот түвшний хүрээнд хөрөнгийг зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 10,724.0 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

3. Тухайн байгууллагын 6 дугаар зуух, 10 дугаар зуухны барилга нь байгууллагын өмчид бүртгэлгүй, тайлант хугацаанд хөрөнгийн элэгдэл тооцоогүй байгаа нь: Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн хөрөнгөд бүртгэлгүй зуухны барилгыг хөрөнгөөр бүртгэж, баталгаажуулах албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 133 мэдээллийг хугацаандаа, 12 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлгүй, өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэх хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны ажил гүйлгээг түүвэрлэн шалгахад нийт 39,123.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй, шууд өртгийн дансанд бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

НББ-ийг аккруэль сууриар хөтөлж, тооцоог шууд зардалд бүртгэн тайлагнахгүй байх

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд үүссэн 2,328.0 мянган төгрөгийн дараа тооцооноос 71.0 мянган төгрөгийн тооцоог тухайн хугацаанд хааж, 2,257.0 мянган төгрөгийн үлдэгдэл тооцоог жилийн эцэст хааж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Дараа тайлангийн тооцоог тухай бүрт бүртгэж, тайлагнаж байх

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 2,821,050.1 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийг ашигласан хугацааны туршид байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн элэгдлийг ашигласан хугацааны туршид байгуулж, тайлагнаж байх

4. Бараа материалын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Бараа материалын орлого, зарлагын хөдөлгөөнийг ажил гүйлгээ гарсан хугацаанд нь хариуцсан нярав бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын орлого зарлагыг гүйлгээ хийгдсэн тухай бүрт бүртгэж, тайлагнаж байх

5. Бараа материалын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Үйлдвэрлэж байгаа дулаан, усыг бэлэн бүтээгдэхүүний дансанд бүртгэхгүй гарсан зардлаар нь дуусаагүй үйлдвэрлэлийн нэгтгэл данснаас борлуулалтын өртгийн дансанд бичилт хийн бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Бэлэн бүтээгдэхүүний бүртгэл, ББӨ-ийн тооцооллыг үнэн зөв гүйцэтгэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---------------------------------|----------------------------|------------------------|---|--|--------------------------|----------|-----------|-----|-----|-----|-----------------|-----|-------------------|----------|---------|----------|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ | ТӨА-2022/02/НА-СТА-ОНА | Байгууллагын 2021 оны зорилтот түвшний батлагдсан төлөвлөгөөг тайлант оны гүйцэтгэлтэй тулган шалгахад Үнс тээврийн зардлыг 6,280.9 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 3,422.3 мянган төгрөгөөр, шагнал урамшууллын зардлыг 1,186.7 мянган төгрөгөөр, нийт 10,889.9 мянган төгрөгийн худалдан авалтыг батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан | Албан шаардлага хүргүүлэв | 1 | 10,889.9 | | | | | | | 1 | 10,889.9 | | |
| 2 | Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ | ТӨА-2022/02/НА-СТА-ОНА | Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 10,724.0 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй | Албан шаардлага хүргүүлэв | 1 | 10,724.0 | | | | | | | 1 | 10,724.0 | | |
| 3 | Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ | ТӨА-2022/02/НА-СТА-ОНА | Тухайн байгууллагын 6 дугаар зуух, 10 дугаар зуухны барилга нь байгууллагын өмчид бүртгэлгүй, тайлант хугацаанд хөрөнгийн элэгдэл тооцоогүй | Албан шаардлага хүргүүлэв | 1 | - | | | | | | | 1 | - | | |
| 4 | Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ | ТӨА-2022/02/НА-СТА-ОНА | Тайлант хугацааны ажил гүйлгээг түүвэрлэн шалгахад нийт 39,123.3 мянган төгрөгийн төгрөгийн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй, шууд өртгийн дансанд бүртгэж тайлагнасан | Зөвлөмж өгөв | 1 | 39,123.2 | | | | | | | | | 1 | 39,123.2 |
| 5 | Төв Чандмань ДЭХГ | ТӨА-2022/02/НА- | Тайлант хугацаанд үүссэн 2,328.0 мянган төгрөгийн дараа тооцооноос | | 1 | 2,257.0 | | | | | | | | | 1 | 2,257.0 |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|----------------------------|------------------------|--|---------------------------|----------|-----------------|--|--|--|--|--|--|----------|-----------------|--|--|--|--|--|---|----------|-----------------|
| | ОНӨААТҮГ | СТА-ОНА | 71.0 мянган төгрөгийн тооцоог тухайн хугацаанд хааж, 2,257.0 мянган төгрөгийн үлдэгдэл тооцоог жилийн эцэст хааж тайлагнасан | Зөвлөмж өгөв | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ | ТӨА-2022/02/НА-СТА-ОНА | Тайлант хугацаанд 2,821,050.1 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийг ашигласан хугацааны туршид байгуулаагүй | Зөвлөмж өгөв | 1 | - | | | | | | | | | | | | | | 1 | - | |
| 7 | Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ | ТӨА-2022/02/НА-СТА-ОНА | Бараа материалын орлого зарлагын хөдөлгөөнийг ажил гүйлгээ гарсан хугацаанд нь хариуцсан нярав бүртгээгүй | Зөвлөмж өгөв | 1 | - | | | | | | | | | | | | | | | 1 | - |
| 8 | Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ | ТӨА-2022/02/НА-СТА-ОНА | Үйлдвэрлэж байгаа дулаан, усыг бэлэн бүтээгдэхүүний дансанд бүртгэхгүй гарсан зардлаар нь дуусаагүй үйлдвэрлэлийн нэгтгэл данснаас борлуулалтын өртгийн дансанд бичилт хийн бүртгэсэн | Зөвлөмж өгөв | 1 | - | | | | | | | | | | | | | | | 1 | - |
| ДҮН | | | | | 8 | 62,994.1 | | | | | | | 3 | 21,613.9 | | | | | | | 5 | 41,380.2 |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ | ТӨА-2022/02/НА-СТА-ОНА | Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 133 мэдээллийг хугацаандаа, 12 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлгүй, өмнөх аудитаар өгөгдсөн албан 5шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй | Албан шаардлага хүргүүлэв | 1 | - | | | | | | | 1 | - | | | | | | | | |
| ДҮН | | | | | 1 | - | | | | | | | 1 | - | | | | | | | | |
| НИЙТ ДҮН | | | | | 9 | 62,994.1 | | | | | | | 4 | 21,613.9 | | | | | | | 5 | 41,380.2 |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn